



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

Санхүүгийн тайланг

батлах тухай

Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлын шийдвэр болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр” ХК-ийн 2017 оны сүүлийн хагас жилийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайланг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан санхүүгийн тайланд дурьдагдсан аудитын байгууллагын санамж, зөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар: 02

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 6-р бүлгийн 46-р зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. "Гермес центр" ХК-ийн 2017 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашиг 415 409 314.79 төгрөг, өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 15 254 348.69 төгрөг, нийт 430 663 663.48 төгрөгийн
 - 91.16 %-ийг буюу 392 715 005.00 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар
 - 8.84 %-ийг буюу 37 948 658.48 төгрөгийг компанийн цалин урамшуулал болон нөөцийн санд тус тус хуваарилсугай.
2. "Гермес центр" ХК-ийн 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар: 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46-р зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2017 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 5.00 төгрөг/таван төг/-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 02-р сарын 15-ны өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны сүүлийн хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2018 оны 03-р сарын 06-ны өдрөөс эхлэн олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот


Хувьцаа эзэмшигчдийн ээлжит

хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60.2-р зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 03-р сарын 07-ны өдрийн 15:00 цагт компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1 Компанийн 2017 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
 - 2.2 Компанийн 2017 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
 - 2.3 Компанийн 2016 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2017 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2018 оны ногдол ашгийн тухай
 - 2.4 Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай
 - 2.5 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
 - 2.6 Компанийн 2018 оны үйл ажиллагааны зорилтын тухай
 - 2.7 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 02-р сарын 15-ны өдрөөр тогтоож, 2018 оны 01-р сарын 25-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн биржид хүргүүлсүгэй.
4. Хурлын товыг 2018 оны 01-р сарын 29, 2018 оны 02-р сарын 12-ны өдрүүдэд Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг 1 дугаар хавсралтаар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн дотор брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсыг 3 дугаар хавсралтаар баталж, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2018 оны 03-р сарын 07-ны өдрийн 18:00 цагаар тогтоосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



Зар түгээх мэдээллийн хэрэгслүүдийн жагсаалт:

- Өдрийн сонин, Өнөөдөр сонин
- UBS телевиз, MN25-р суваг телевиз,
- Fm-98.9 радио, МҮОНРадио

Зар гаргах өдрүүд : 2018 оны 01-р сарын 29-ний өдөр, 2018 оны 02-р сарын 12-ны өдөр

“ТЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Термес центр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 03-р сарын 07-ны өдрийн 15:00 цагт тус компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд болох тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа морилон ирэхийг урьж байна.

Бүртгэлийн өдрийг 2018 оны 02-р сарын 15-ны өдрөөр тасалбар болгоно.

Хурлаар хэлэлцэх асуудал :

- Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
- Компанийн 2017 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
- Компанийн 2016 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2017 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2018 оны ногдол ашгийн тухай
- Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, диллерийн компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 4-р хороо, Нарны зам-20, “Термес центр”ХК-ийн төв оффисын байрны 3 давхар № 302 тоот өрөөнд хүрэлцэн ирж танилцаж болно.

Хурал зохион байгуулах:

Комиссын дарга: О.Энхтуяа, утас 9909-4991, имэйл хаяг:enkhee_7777@yahoo.com

Гишүүн: Д.Эрдэнэсүрэн, утас 9908-8571, имэйл хаяг: erdenee.0922@yahoo.com

Жич : 2 сонинд зарыг гаргахдаа аудитын дүгнэлт болон санхүүгийн хураангуй тайланг хамт хэвлүүлэн гаргана.



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар: 06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион
байгуулах комиссыг томилох тухай

Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 01-р сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд :
 - 1.1. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга /Д.Оюунсүрэн/
 - 1.2. Комиссын даргаар нягтлан бодогч /О.Энхтуяа/, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Эрдэнэсүрэн/, ажилтан /Л.Оюунгэрэл/
2. Хурал зохион байгуулах комисс нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан холбогдох журмын дагуу ажиллахыг үүрэг болгосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлыг компанийн үйл ажиллагааны холбогдох зардлаас гаргахыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/-т даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

201 ⁸ онь ⁰¹ сарын ¹⁴ өдөр

Дугаар: ⁰⁷

Улаанбаатар хот

Тооллогын комиссыг

батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.2-р заалт болон, Компанийн дүрмийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - Тооллогын комиссын даргаар : Нягтлан бодогч /О.Энхтуяа/
 - Тооллогын комиссын гишүүдээр : ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Эрдэнэсүрэн/, ажилтан /Л.Оюунгэрэл/
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг холбогдох хууль, журмын дагуу бүртгэж, хурлын ирцийг танилцуулахыг Тооллогын комисс /О.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУНСҮРЭН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	"Гермес Центр"ХК
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 4-р хороо, Нарны зам-20, "Гермес Центр"ХК-ийн төв оффисын байр, холбогдох Утас: 30-15-77, 99 08 85 71
Хурал хуралдах өдөр, цаг:	2018 оны 03-р сарын 07-ны өдрийн 15.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/ :	Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 4-р хороо, Нарны зам-20, "Гермес Центр"ХК-ийн оффисын байрны 3-р давхарт
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдуулах шийдвэр гаргасан огноо:	2018 оны 01-р сарын 24-ний өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2018 оны 01-р сарын 29-ний өдөр
Бүртгэлийн өдөр:	2018 оны 02-р сарын 15-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:	2018 оны 02-р сарын 02-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2018 оны 01-р сарын 25-ны өдөр
Хурлын даргын нэр:	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссын дарга О.Энхтуяа, гишүүд Д.Эрдэнэсүрэн, Л.Оюунгэрэл
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хурал хуралдуулах тухай ТУЗ-н тогтоол, хавсралтууд
Баримт, бичгийн хуудасны тоо:	ширхэг
	хуудас



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

...../О.Энхтуяа /

2018 оны 01-р сарын 25-ны өдөр